



Хичээлийн сэдэв: ТӨР ИРГЭНИЙ ХАРИЛЦААГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Өмнөх хичээлээр :

ТӨР ОРШИХУЙН УЧИР



ТӨРИЙН ШИНЖ



ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ

ЗАСАГЛАЛ
ГЭЖ ЮУ
ВЭ?

ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭР, БАЙГУУЛАМЖИЙН
ХЭЛБЭР



Төрийн дэглэм




Төр иргэдийн харилцаа бэхжих нь нэг талаас иргэдийн төр засагтаа итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нөгөө талаас төрийн хувьд иргэдийнхээ итгэлийг олж байр сууриа бэхжүүлэх ач холбогдлыг агуулдаг.



Төр иргэдийг зохион байгуулахдаа өөрийн гэсэн арга барил, дүрэм журмыг тогтоодог бөгөөд үүнийг төрийн дэглэм гэх ойлголтоор илэрхийлдэг.



Ардчилсан



Ардчилсан бус



ТӨРИЙН ДЭГЛЭМ



Төрийн эрх мэдлийг ард түмний хүсэл зориг, эрх, эрх чөлөө, сайн дурын хүлээн зөвшөөрөлт, эрх зүйт хуульд тулгуурлан хэрэгжүүлж байгаа улс орнуудыг **ардчилсан дэглэмтэй** гэж үзнэ.

АРДЧИЛСАН ДЭГЛЭМ

ЛИБЕРАЛЬ

КОНСЕРВАТИВ

ОКЛОКРАТ



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Консерватив ардчилсан дэглэм. (conservare - хадгалах гэсэн утгатай франц үг)

1. Төрийн нэр хүнд, уламжлалт чиг үүрэгт хүндэтгэлтэй ханддаг
2. Нийтийн сайн сайхан, үндэсний уламжлалт үнэт зүйлийг хамгаалах үүднээс төрийн хууль ёсны оролцоо, зохицуулалтыг харьцангуй өндөр түвшинд хадгална.
3. Хүний салшгүй эрх болсон өмчлөх эрхийг хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмын баталгаа гэж үздэг төр улсыг үүнд багтаана.

Либерал ардчилсан дэглэм. (liberalis - эрх чөлөө гэсэн утгатай латин үг)

1. Нийгмийн амьдралд хамгийн бага оролцоотой (Minima State) дэглэм бөгөөд үндсэн үүрэг нь хулгай, залилан, хүчирхийлэл зэргээс хувь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахаар хязгаарлагддаг.
2. Хүний эрх, эрх чөлөө дээдлэгдэнэ.
3. “Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө” гэсэн зарчмыг мөрдлөгө болгодог улсууд энэ ангилалд орно.



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Охлократ ардчилсан дэглэм. (ochlos - энгийн олон түмэн гэсэн утгатай грек гаралтай үг)

1. Ардчилсан бус дэглэмээс ардчилсан дэглэмд шилжих шилжилтийн үеийн дэглэмтэй улс энэ ангилалд хамаарна.
2. Энэ ангилалд багтаж буй улс ардчиллын үнэт зүйлсийг ард түмний дуу хоолой, шахалтаар хэрэгжүүлж байдаг онцлогтой.
3. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ эрх зүйт бус хуульд дулдуйдан албадлага, хүчирхийллийн аргаар эрх баригчдын дур зоригийн ноёрхлыг тогтоосон төр улсуудыг ардчилсан бус дэглэмтэй гэж үзнэ.



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Ардчилсан дэглэм

Гол шинж нь:

Өмчийн олон хэлбэр,

Иргэний нийгмийн зарчим,

Эрх зүйт төр

Олон намын тогтолцоо

Улс төрийн плюрализм

Хүний эрх, эрх чөлөөг
хамгаалах, хангах,
баталгаажуулах

Ардчилсан бус дэгдэм

Гол шинж нь:

*Засгийн эрхийг нэг буюу
цөөн хэдэн хүний хүрээнд
төвлөрүүлж, төрийн
аливаа ардчилсан үйл
явц, сонгууль, хүний эрх,
эрх чөлөөг бүрэн буюу
ямар нэг хэмжээгээр
хориглон хязгаарлаж, нэг
үзэл сурталд захируулж
байдаг явдал юм.*



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Төрийн ардчилсан хэв маягийн илрэл нь

- Эрх зүйт төр
- Социаль төр юм.

О.АЛТАНГЭРЭЛ
Хуульч

“ЭРХЗҮЙТ ТӨР
БҮТЭЭХИЙН ТУЛД МАНАЙ
УЛСТӨРИЙН СИСТЕМЭЭС
ӨӨРӨӨС НЬ ЭХЭЛЖ
МАНЛАЙЛАЛ, ӨӨРӨӨС НЬ
ЭХЭЛЖ ХҮЧ ГАРАХ ЁСТОЙ”



SYNDICATE TALK
WITH VIDEO

Эрх зүйт төр нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө эрх зүйт хуулийг дээдэлдэг төр ёсны мөн чанар буюу төр, иргэний нийгэм хоёр эрх зүйт хуулийн үндсэн дээр харьцангуй тэнцвэртэй орших арга, загвар юм.

Эрх зүйт төрийн үндсэн шинжүүд

- Хуулийн засаглал
- Төр иргэн 2 харилцан хариуцлага хүлээх
- Төрөөс хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, баталгааг нь хангах
- Төрийн эрх мэдэл хуваарилах
- Шүүх зөвхөн хуульд захирагдах



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Байгаль, нийгмийн олон хүчин зүйлээр нөхцөлдсөн, тэгш бус хүмүүсийн амьдралын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад чиглэсэн нийгмийн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маяг бол **социаль төр** юм.

- Амьдралын наад захын баталгааг тогтоон хуульчлах
- Нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хамгаалах
- Социаль төр шаардлага тулгарсан үед иргэдэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Тоталитар улс төрийн дэглэм.

- Тоталитаризм гэсэн хэллэг нь латин хэлний «to-talitas» буюу бүхэл, бүтэн гэсэн үгнээс гаралтай бөгөөд анх 1925 онд италийн фашизмыг үндэслэгч Б.Муссолини өөрийн улс төрийн хөдөлгөөнийг тодорхойлон хэрэглэсэн байдаг.
- Тоталитаризм нь нийгмийн бүх үзэгдэлд туйлын хяналт тогтоохыг эрмэлздэг улс төрийн дэглэм юм. Тийм ч учраас бүх нийтээр хянан захирах дэглэм гэж тодорхойлж болох бөгөөд (тушаагдаагүй бүхэн хориглогдоно» гэсэн зарчимд тулгуурлаж байдаг.
- Тоталитар дэглэм бий болох ШАЛТГААН нь хувьсгал, дайны ялагдал, дотоодын зөрчилдөөн, эдийн засгийн хямрал, ядуурал хоосрол, ажилгүйдэл, үүнээс үндэслэн хүчтэй төрийг хүсэмжлэх сэтгэлгээ, тоталитар үзэл суртлыг номлогч улс төрийн хүчин зэрэг юм.



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Тоталитаризмын үндсэн шинжүүд нь:

- Нийгмийн бүх давхаргыг цорын ганц «үнэн» болсон **НЭГ ҮЗЭЛ СУРТАЛД** хүчээр захируулж, өөр урсгал чиглэлийг үл тэвчин мэдээллийг бүрэн хяналтандаа байлгадаг. Үзэл номлолоос нь зөрчсөн хэнийг ч болов улс төрийн дайснаа гэж үзнэ. Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг бүрмөсөн үгүйсгэнэ.
- Төрөөс ард түмнийг бүрэн хараат байлгах бүхэл бүтэн тогтолцоо механизм бүрдүүлэхийг чармайж, нийгмийн амьдарлын бүхий л хүрээ, хувийн амьдарлыг хүртэл **ХЯНАЛТАНДАА БАЙЛГАДАГ**. Төржсөн намын байгууллага улс төрийн системийг манлайлж, нийгэм эдийн засаг, үзэл суртлын амьдарлыг чиглүүлэх үүрэг хүлээнэ.
- Албан ёсоор нам, **төрөөс ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ЯМАР Ч УЛС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨДӨЛГӨӨН ОРШИН ТОГТНОХ ҮНДЭСГҮЙ**, цэрэг, цагдаа нь сөрөг хүчний болзошгүй эсэргүүцлийг дарах нэг гол үүрэгтэй.
- Нийгмийг дотор нь анги, яс үндэс, арсны өнгө зэрэг байдлаар зааглан ялгаж, **НЭГИЙГ НӨГӨӨГӨӨС НЬ ДЭЭГҮҮР ТАВИХ**, нийгмийн гишүүдийг зэрэглэн дугаарлах хатуу систем үйлчилнэ. Жишээ нь коммунистууд ажилчин ангийг, нацистууд ари үндэстэнг бүхнээс дээгүүр тавьдаг.
- Хувийн өмчийг бүрмөсөн устгаж (эсвэл төрийн хяналтанд бага хэмжээнд зөвшөөрөх), чөлөөт өрсөлдөөнийг үгүйсгэн улс орны **ЭДИЙН ЗАСГИЙГ ХАТУУ ХЯНАЛТАНД** авна.



ТӨРИЙН ДЭГЛЭМ

А) Түүний зүүний чиглэл болох коммунизм, социализм түүний дотор сталинизм, маоизмын хэлбэрээр илэрч байв. Хуучин ЗХУ, социалист системийн орнууд үүний тод жишээ болно. Одоо хойт Солонгос, Кубад ийм дэглэм оршин тогтнож байна.

Б) Тоталитаризмын барууны чиглэл нь 1922 оны италийн Муссолины фашист дэглэм, германы нацизм, тэрчлэн цэргийн дэглэм юм.



ТӨРИЙН ДЭГЛЭМ

Авторитар улс төрийн дэглэм. Авторитаризм нь нэг буюу хэсэг хүмүүсийн захиран дарангуйлах улс төрийн дэглэм бөгөөд тоталитар болон ардчилсан дэглэмийн хоорондод завсрын хэлбэр юм.

Уг дэглэмийн гол онцлог нь тоталитар дэглэм шиг нийгмийн амьдарлын бүх хүрээг хянадаггүй, нэгдмэл үзэл суртал тулгадаггүй, эдийн засаг хувийн амьдарлын хүрээнд тодорхой хэмжээний эрх чөлөө олгож, иргэний нийгмийн зарим шинж төрхийг агуулдгаараа тоталитар дэглэмээс ялгагдан үүгээрээ ардчилсан дэглэмтэй төстэй болдог.


Улс төрийн засаглалын гол шинж нь хүч хэрэглэх биш нэр хүнд байх ёстой гэж үздэг. "Улс төрөөс бусдыг зөвшөөрнө" гэсэн зарчмыг удирдлага болгодог.

Авторитар дэглэмийн үндсэн шинжүүд нь:

- Төр засаглалын эрх мэдэл улс төрийн лидер юмуу тодорхой нэг бүлгийн гарт бүрэн төвлөрсөн байна. Дарангуйлалд тулгуурласан байна.
- Төрийн гарт тулгамдсан, гол чухал нийгмийн бүх асуудлууд байна.
- Засаг төр хуулийн хүрээнд эрх мэдлээ хэрэгжүүлж болох боловч энэ хууль зөвхөн тэдний өөрсдийнх нь хүсэл зоригийн илэрхийлэл болно. Энэ утгаараа эрх мэдэл нь хязгааргүй ба ямар нэг хяналтгүй байна.
- Улс төрийн эрх хязгаарлагдмал боловч засаг төрд дуулгавартай цөөн тооны нам, үйлдвэрчний болон бусад байгууллага оршин тогтнохыг зөвшөөрдөг тохиолдол бий.
- Улс төрийн дээд давхарга буюу элитийг шударга сонгуулийн зарчмаар бус дээрээс сонгон шалгаруулах замаар бүрдүүлнэ. Сонгууль, парламент байх боловч тэр нь ихэнхдээ билэгдлийн чанартай байна.
- Улс төрөөс бусад ялангуяа эдийн засгийн салбарт бүрэн хяналт тавьдаггүйгээрээ тоталитаризмаас ялгаатай. Засаг төр эн тэргүүнд өөрсдийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, батлан хамгаалах болон гадаад бодлогодоо анхаарлаа хандуулдаг.

Авторитар дэглэмийг хатуу, ардчилсан, аядуу зөөлөн гэж ангилж болно.

Хүн төрөлхтний түүхэнд авторитар дэглэм нь хамгийн түгээмэл нийгэм-улс төрийн тогтолцоо юм. Авторитар дэглэм ихэнхдээ шинэ тулгар хөгжиж байгаа орнууд, ази, африк, латин америкт түгээмэл ажиглагддаг. Эдгээрээс зарим нь ардчилсан шинж төрхийг олж, нөгөө нь тоталитар дэглэм болж хувьсан өөрчлөгдөж байна.



АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.